



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 05 сарын 28 өдөр

Дугаар А/313

Есөнбулаг сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.13 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаал Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.1 дэх заалт, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.15, 7.16 дахь заалт, Аймгийн Онцгой комиссын 2026 оны 3 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Баян-Өлгий аймагт малын гоц халдварт шүлхий өвчин (SAT-1) гарсантай холбогдуулан Тонхил сумын Барлагийн ам, Дарив сумын Далан түрүүд 2026 оны 05 дугаар сарын 29-ний өдрөөс 06 дугаар сарын 28-ны өдөр хүртэл хяналтын цэгийг зохион байгуулсугай.

2.Хяналтын цэгт ажиллах албан хаагчдыг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

3.Шаардагдах зардлын тооцоог хоёрдугаар хавсралтаар баталсугай.

4.Халдваргүйтгэлийн арга хэмжээнд шаардагдах халдвар хамгааллын хувцас, халдваргүйтгэлийн бодис, багаж тоног төхөөрөмж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, мэдээллийг цаг тухайд нь илтгэж ажиллахыг Мал эмнэлгийн газар (Р.Бүрэнбаясах)-т үүрэг болгосугай.

5.Дээрх ажилд шаардагдах 5.000.000 (таван сая) төгрөгийг гамшгийг хамгаалах зардлаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын дарга(Д.Эрдэнэжаргал)-д зөвшөөрсүгэй.

6.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (М.Алтангэрэл)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Г.ЧИНБАТ



Аймгийн Засаг даргын 2026 оны
05 дугаар сарын 28-ны өдрийн А/дүгээр
захирамжийн нэгдүгээр хавсралт

ТОНХИЛ СУМЫН БАРЛАГИЙН АМЫН ХЯНАЛТЫН ЦЭГТ АЖИЛЛАХ АЛБАН
ХААГЧДЫН НЭР

№	Албан хаагч, мэргэжилтнүүдийн нэрс	Байгууллага	Албан тушаал	Утасны дугаар
1	Д.Наянбуу	Мал эмнэлгийн газар	МАЭМХБХэлтсийн дарга	99488146
2	Л.Одбаяр	Мал эмнэлгийн газар	Жолооч	99448382
3	О.Дамдинбазар	Цагдаагийн газар	Хэсгийн цагдаа, ахлагч	94989992
4	Б.Отгонбилэг	Онцгой байдлын газар	Эрэн хайх аврах, салбарын аврагч, дэд ахлагч	89806247
5	Д.Содбаатар	Сумын Тамгын газар	Байгаль хамгаалагч	93221148

ДАРИВ СУМЫН ДАЛАН ТҮРҮҮ ХЯНАЛТЫН ЦЭГТ АЛБАН
ХААГЧДЫН НЭР

№	Албан хаагч, мэргэжилтнүүдийн нэрс	Байгууллага	Албан тушаал	Утасны дугаар
1	Г.Төмөрсүх	Мал эмнэлгийн газар	Ийлдэс судлаач	98487747
2	Ш.Энх-Амгалан	Мал эмнэлгийн газар	Жолооч	98952503
3	А.Амартүвшин	Цагдаагийн газар	Хэсгийн цагдаа, ахлагч	88481480
4	Ч.Баттулга	Онцгой байдлын газар	Эрэн хайх аврах,салбарын аврагч-химичин, ахлагч	88590598
5		Сумын Тамгын газар		

Аймгийн Засаг даргын 2026 оны
05 дугаар сарын 08-ны өдрийн 31/2 дүгээр
захирамжийн хоёрдугаар хаваралт

ХЯНАЛТЫН ЦЭГТ ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТООЦОО

Шатахууны зардал

№	Зардлын төрөл	Явах км	Шаардагдах шатахуун /л/	1 л шатахууны үнэ	Нийт
		Аймаг сум хооронд			
1.	Тонхил чиглэлд	790*3=2370	158*3=474	3000	1422000
2.	Дарив чиглэлд	480*3=1440	96*3=288	3000	864000
ДҮН		3810	762	3000	2.286.000

Хоол хүнсний зардал

№	Зардлын төрөл	Тоо	Нэг бүрийн үнэ	Нийт
1.	Мах /кг/	25*3=75	220000	1650000
2.	Хүнсний бүтээгдэхүүн, гурил, гурилан бүтээгдэхүүн			1064000
ДҮН				2.714.000

Зардлын товчоо

№	Зардлын төрөл	Нийт
1.	Шатахууны зардал	2286000
2.	Хоол хүнсний зардал	2741000
Нийт		5.000.000